



И ЭС ЭМ ОЛОН УЛСЫН ДУНД СУРГУУЛЬ

Сурагч хамгааллын бодлого, журам

Сурагч хамгааллын бодлого, журам

1. Хамгааллын бодлогын зорилго

Манай бодлогын 3 үндсэн элемент:

- 1.1. Заах болон халамжлах арга ухаанаар сурагчдыг дэмжин, урьдчилэн сэргийлэх.
- 1.2. Гэмт хэрэг, сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх, тайлагнах журам. Сурагчидтай өдөр бүр харилцдаг гэдэг утгаараа сургуулийн багш, ажилчид аливаа төрлийн гэмт хэрэг, хүчирхийллийн шинж тэмдгийг сайтар ажиглах.
- 1.3. Хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй сурагчид туслах, дэмжлэг үзүүлэх.

Энэхүү бодлого нь тус сургуулийн барилга дотор буй бүх ажилчин, ажиллагсад хамаарна. Сурагчид анхлан туслах багш, захиргааны ажилчин, багш хэнд ч хандаж болно. Сэтгэл нь зовиносон эцэг эх ч сургууль руу хандаж болно.

2. Сургуулийн хамгаалал: Урьдчилан сэргийлэх арга.

Бид үлгэр дуурайлал болдог, өөртөө итгэлтэй, дэмжлэг үзүүлж чаддаг найз нөхөд болон итгэл даах, харилцаа холбоо сайтай насанд хүрэгчдийн тусламжаар урьдчилан сэргийлэлтийг хийх боломжтой гэж үзэж байна. Үүний тулд сургууль:

- 2.1. Сурагч өөрсдийгөө аюулгүй байгааг мэдэрдэг, илэн далангүй ярилцах боломжтой, тэднийг сонсдог ёс суртахууныг бид бий болгох, түүнийгээ хадгалж үлдэх.
- 2.2. Сурагч таагүй, хүндрэлтэй үедээ тусламж хүсэн хандах насанд хүрсэн хүн сургууль дээр нь байгааг мэдэх мэдлэгээр хангах.

- 2.3. Хүчирхийллээс хамгаалагдах, хэнээс тусламж хүсэхээ мэдэх чадварыг эзэмшүүлэх Хувь хүний хөгжил, нийгмийн харилцаа, эрүүл мэндийн боловсрол /PSHE/-ын хөтөлбөрийг үйл ажиллагаандаа тусгах.
- 2.4. Хүүхдэд туслах үүднээс насанд хүрэгчдийг илүү хариуцлагатай байлгах амьдарлын бодит хандлага тухайлбал хүүхэд асрах, эцэг эхийн ур чадварыг хөгжүүлэх материалыг сургалтын хөтөлбөрт оруулах.

3. Хамгааллын журам: Нийтлэг үндэслэл

- 3.1. Сургуульд хүүхэд хамгааллын чиглэлээр зохих сургалтанд хамрагдсан 2 удирдах албаны багшийг томилсон ба тэдгээр нь Вардухи Григорян, Жак Мийдөв нар болно. Сургуулийн захирал болон Орлогч дарга мөн сургалтанд хамрагдсан.
- 3.2. Сургуулийн бүх ажилтан, ажиллагсад, удирдлага томилогдсон хүн болон түүний үүргийг мэддэг байх.
- 3.3. Сургуулийн бүх ажилтан, ажиллагсад хүчирхийллийн шинж тэмдгийг ажиглан сэрэмжтэй байхыг мэддэг байх, сурагч хүчирхийллийн талаар мэдээллэх үед хэрхэн хариу өгөхөө мэддэг байх.
- 3.4. Сургууль бол хариуцлагатай газар, хүүхдийг хамгаалах нь багш, ажилчдын үүрэг болохыг бодлого болон бусад холбогдох материалд тусгасныг эцэг эхчүүд мэддэг байх. Тус бодлогыг цохон онцолж, зохих газар үүнийг ашиглана уу.
- 3.5. Зохих сургалтанд бүх багш, ажилчдыг хамтруулах.
- 3.6. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй холбогдох агентлагуудтай үр дүнтэй уялдаа холбоог бий болгох чиглэлээр ажиллах, хүүхэд хамгааллын асуудлаар шаардлагын дагуу хамтран ажиллах.
- 3.7. Эцэг эх, хөндлөнгийн байгууллагад мэдэгдэх шаардлага байхгүй гэж үзсэн байсан ч хүүхэдтэй хобоотой аливаа асуудлыг (үйл явдлын огноо, болсон үйл явц, авсан арга хэмжээ) тогтмол тэмдэглэн, протокол хөтлөж, хадгалж байх.
- 3.8. Бүх баримт нотолгоог аюулгүй, найдвартай хадгалах.
- 3.9. Сурагчидтай ёс бус, зүй зохисгүй харилцаа үүсгэсэн аливаа багш, ажилтанг нэн даруй шалгаж, гэмт хэргийн шинж чанартай бол холбогдох хуулийн байгууллагад мэдэгдэх.
- 3.10. Үүссэн тохиолдол/хэрэг маргаан бүр өөр өөр байж болох тул хяналтын хуудсыг гол чиглүүлэг болгон ашиглана.

3.11. Багш, ажилчдыг ажилд авахдаа цагдаагийн газрын тодорхойлолт, өмнөх ажлын газрын 2 оо дээс тодорхойлолтыг үндэслэдэг ажлын сонгон шалгаруулалтын бодлогыг боловсруулж, ашиглах.

3.12. Эцэг эхчүүд гэр бүлийн байдалдаа гарсан аливаа өөрчлөлт, хүүхэд гэмтэж бэртсэн, осол аваарт орсон зэрэг мэдээллийг үнэн зөвөөр сургуульдаа мэдэгдэж, тухайн сурагч дээрхи өөрчлөлт, болсон үйл явдлаас нөлөөлөх алив сөрөг тохиолдолд сургууль нь тухайн сурагчид тусламж үзүүлэх боломжоор хангах.

4. И Эс Эм аюулгүй байдал: Сурагчдыг эрэсдэлд өртөхөөс сэргийлэх

Хүчирхийлэлд өртсөн эсвэл гэрч болсон сурагч хувь хүнийхээ үнэлэмжийг аллах улмаар дэлхий ертөнцийг сайн сайхан, утга учиртай газар гэж ойлгоход нэн бэрх болдог. Энэ үедээ тэд хэн ч тэдэнд туслахыг хүсэхгүй гэж мэдрэх, өөрсдийгөө буруутгах, басамжлал, доог тохууг мэдэрэх нь элбэг байдаг. Тиймээс сургууль тэдний хувьд хамгийн найдвартай, аюулгүй, аливаа эрэсдэлийг урьдчилан тооцоолж, арга хэмжээ авдаг газар байх юм. Гэсэн ч сурагчид сургуулийн орчинд байх үед харилцан бие биенээсээ зан байдлын сорилд орж болох юм. Иймд сургууль нь дараахи байдлаар сурагчдаа дэмжих эрмэлзэнэ.

4.1. Сургалын хөтөлбөрийн агуулга хувь хүний хөгжил, өөртөө итгэлтэй байдлыг заах, хөхүүлэх дэмжихэд чиглэсэн.

4.2. Сургуулийн ёс зүй, эрхэм чанарын бодлого нь ¹эрэг хандлагыг уриалсан, ²дэмждэг аюулгүй орчинг бүрдүүлсэн, ³сурагчдад үнэ цэнийг нь өгч чадах газар байх.

4.3. Боловсролын чиглэлийн сэтгэл судлаач, эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах.

4.4. Асуудал гарвал дахин бүртгэл хөтөлж, хадгалах. Сурагч шилших болвол шилжин очсон шинэ сургуульд цаг алдалгүй хадгалсан мэдээллийг дамжуулна. Нийт сурагчдын тухайд сургууль нь тэдний аюулгүй байдлыг хангах газар мөн болохыг ойлгуулах, алив төрлийн хүчирхийллийг мэдэж, үүнийг цааш гааруулахгүй байлгах анхан шатны мэдлэгтэй болгоход PSHE хичээл, бүлгийн уулзалт, цахим аюулгүй байдлын тохиргоо, нийтийн цугларал болох ассембли зэрэг цагуудыг ашиглана.

Сурагчын сайн сайхан байдал, тэдний сэтгэл санаанд санаа зовоох жаахан ч гэсэн зүйл байвал та сургуулийн томилогдсон мэргэжилтэнтэй уулзаж, санаа бодлоо хуваалцана уу. Ихэнх хүчирхийлэл нууц, далд хэлбэрээр явагддаг. Хүчирхийллийн 4 н төрөл байдаг. Үүнд:

- Үл тоогдох/Хайр халамж мэдрэхгүй байх
- Бие мах бодын хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Сэтгэл санааны дарамт

Хэрэв та дээрхи төрлийн хүчирхийллийг олж мэдвэл нэн даруй мэдэгдэх нь таны хариуцлага юм.

2017 оны 6 сар

Сурагч хамгааллын хариуцсан ажилтанд мэдээллэх Сурагч хамгааллийн журмын Хяналтын хуудас.

Бүх асуудлыг нэг бүрчлэн бичээд хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө. Үүний дараа тухайн асуудлаас хамааран дүгнэлт гаргаж, авах арга хэмжээг бичиж тэмдэглэнэ.

Сурагчийн нэр: _____ Анги: _____

	Боломжит арга хэмжээ	Огноо
1	Хэргийн талаар тэмдэглэл хөтлөж, холбогдох багш нар тухайн асуудалд хяналт тавих	
2	Сургуулийн эмч, аж ахуйн дарга гэх мэт бусад салбарын ажилчдаас зөвлөмж авах	
3	Бусад багш, ажилчидтай ярилцах	
4	Тухайн хүүхэдтэй хамаарах бүх ажилчидтай ярилцаж, нягт нямбай хяналт тавих	
5	Тухайн сурагчтай болгоомжтой ярилцах	
6	Асуудалд холбогдсон нөгөө сурагчтай мөн ярилцах	
7	Тодруулга хийх зорилгоор нэг эсвэл 2 талын эцэг эхийг дуудах	
8	Эцэг эхийг хүүхдээ мэргэжлийн эмчид үзүүлж, шинэжилгээ хийлгэхийг зөвлөх	

- 9 Ноцтой асуудал бүрийг холбогдох хуулийн болон бусад байгууллагад мэдээллэх
- 10 Бүх яриа, зөвлөгөөн, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг хөтөлж, эцэг эхийн гарын үсгээр баталгаажуулан хадгална
- 11 Шаардлагатай гэж үзвэл өөр удирдах төвшиний мэргэжилтэнд танилцуулна

АСУУДЛЫГ ТОДРУУЛАХ, ЗӨВ ГАРГАЛГАА ГАРГАХАД ОРОЛЦСОН БҮХ ХҮНИЙ ЗААВАЛ АНХААРАХ ЗҮЙЛС

	Жил бүрийн сануулга	Огноо
1	Жил бүрийн мэргэжил дээшлүүлэх сургалтаар хүүхэд хамгааллын талаар хэлэлцэж байхаар хуваарьт тусга. /Намрын ориштейшн/	
2	Удирдлагын багийн хурлаар жил бүр энэ сэдвийг хөндөж байхаар хэлэлцүүлэгт оруулна. /удирдах багийн хурал/	
3	Хүүхэд хамгааллын сануулга бүхий цахим аюулгүй байдлын талаар ассембли д мэдээллэнэ.	
4	Бүх сурагчдад тулгарч буй асуудлаараа хэнд, хаана хандаж болох талаар мэдээлэл өгнө.	
5	Бүх сурагчдад тэдний аюулгүй байдалд анхаарал хандуулдаг 108 дугаар руу дуудлага хийх мэдлэгийг олгоно.	
6	Эцэг эхчүүдэд сургуулийн бодлогыг тогтмол танилцуулж, шинэ эцэг эхчүүд хүүхэд хамгааллын талаархи сургуулийн бодлогын талаархи мэдээллийг авч болох газрыг хэлж өгнө.	
7	Багш болон эцэг эхчүүдэд нууцлал болон хил хязгаарыг чандлан сахихыг тогтмол сануулна.	

Бичилт, боловсруулалт, хяналт хийсэн мэдээлэл:

Хийсэн боловсруулсан/засварласан/шалгасан)	өөрчлөлт (ж.нь:	Нэр	Огноо
Боловсруулсан		Оливер Жаксон	2016 оны 8 сарын 15
Засварласан		Оливер Жаксон	2017 оны 8 сарын 14
Шалгасан		Майкл Блэйк	2018 оны 8 сарын 13
Шалгасан		Майкл Блэйк	2020 оны 1 сарын 13